



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/68

Улаанбаатар хот

Арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 5/10 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.4.5, 1.4.10, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/636 тоот захирамж, тус газрын Дүрмийн 2.5.3, 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол хоолны соёлыг гадаадын жуулчдад таниулах, бусад улсын хоолны соёлыг эх орондоо түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Олон үндэстний хоолны гудамж” арга хэмжээг “Юби Фүүд Фестиваль” нэрийн доор 2017 оны 09 дүгээр сарын 02-03-ны өдрүүдэд “Шөнийн гудамж”-нд зохион байгуулахыг Хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн /Б.Тулгаа/-д үүрэг болгосугай.

2. Арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсөв болох 12.605.000 /арван хоёр сая зургаан зуун таван мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА *D. Batm* Д.БАТСҮХ



1150500264

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 08 сарын 29  
өдрийн 6 дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт



**“ОЛОН ҮНДЭСТНИЙ ХООЛНЫ ГУДАМЖ”  
АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

2017 оны 8 дугаар сарын 29 ны өдөр

Улаанбаатар хот

**НЭГ. ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ:**

“Олон үндэстний хоолны гудамж” арга хэмжээ нь нийгэмд чиглэсэн, ашгийн бус олон нийтийн арга хэмжээ бөгөөд Монгол хоолны соёлыг гадаадын жуулчдад таниулах, гадаадын жуулчдад зориулсан арга хэмжээнүүдийн тоог нэмэгдүүлэх, бусад улс орнуудын хоолны соёлыг эх орондоо түгээн дэлгэрүүлэх, иргэдийн зохистой хооллолтын талаарх ойлголтыг дээшлүүлэх, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилготой.

**ХОЁР. ХУГАЦАА, ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР:**

“Олон үндэстний хоолны гудамж” арга хэмжээ өдөрлөгийг 2017 оны 09 дүгээр сарын 02, 03-ны өдрүүдэд 2 өдөр “Шөнийн гэрэлт гудамж”-нд зохион байгуулна.

**ГУРАВ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД:**

Ерөнхий зохион байгуулагчаар

- Нийслэлийн Аялал жуулчлалын газар

Хамтран зохион байгуулагчаар

- Шөнийн гэрэлт гудамжны менежментийн баг ажиллана.

**ДӨРӨВ. ОРОЛЦОГЧИД БА ХАМРАХ ХҮРЭЭ:**

Энэхүү өдөрлөгт Гэрэлт гудамжинд үйл ажиллагаа явуулж байгаа хоолны газрууд бүгд оролцоно. Мөн үүнээс гадна арга хэмжээг сонирхолтой болгож, олон үндэстний хоолны соёлыг сурталчлах үүднээс өөр өөр үндэстний хоолны газруудыг сонгон оролцуулна. Өдөрлөгийн үеэр аж ахуйн нэгжүүд өөрсдийн нэрийн бүтээгдэхүүн, улс үндэстний төрөл бүрийн хоол, зууш амттаныг багасгасан хэмжээтэйгээр бэлтгэж, хямд үнээр иргэдэд үйлчилнэ. Арга хэмжээний үеэр зохиогдох урлаг, соёлын тоглолт, үзүүлбэр үзэх, тэмцээн уралдаанд оролцохдоо иргэд, төлбөр хураамж төлөхгүй.

**ТАВ. ТЭМЦЭЭН УРАЛДААН, ШАГНАЛ:**

Уг өдөрлөгт хүрэлцэн ирсэн иргэдэд хамгийн чанартай, амтлаг хоол хүнсээр хурдан шуурхай үйлчилж, олны талархлыг хүлээсэн нэг аж ахуйн нэгжийг “Олон орны хоолны гудамж” арга хэмжээний шилдэг оролцогч, шилдэг тогоочоор шалгаруулан шагнана. Мөн хүрэлцэн ирсэн иргэдийн дунд “Хэн олон хотдог,

бургер идэх вэ?” зэрэг хэд хэдэн төрлийн тэмцээн, уралдаан, янз бүрийн сонирхолтой урлаг, соёлын үзүүлбэрүүдийг зохион байгуулна.

#### ЗУРГАА. ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГАД ТАВИХ ШААРДЛАГА:

- Хууль, журам, стандартын дагуу нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байх, нэгээс доошгүй жил хоол үйлдвэрлэлийн чиглэлээр ажилласан туршлагатай байх

- Арга хэмжээний үеэр эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан хоол, хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлэх, хоол, үйлчилгээ үзүүлэх явцад гарч болох аливаа хүндрэл, эрсдэлийг урьдчилан тооцоолж бэлтгэлийг хангасан байх

#### ДОЛОО. АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛСНААР ГАРАХ ҮР ДҮН:

- Олон орны хоол, үйлчилгээний соёлыг иргэдэд танилцуулж, сурталчилна.

- Иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, жуулчид, Монголд оршин суугаа гадаадын иргэдийн сонирхлыг татах арга хэмжээтэй болно.

- Аялал жуулчлалын идэвхтэй улирлын хугацааг уртасгахад түлхэц үзүүлнэ.

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 08 сарын 29 өдрийн А.68 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



“ОЛОН ҮНДЭСТНИЙ ХООЛНЫ ГУДАМЖ”  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

2017 оны 08 дугаар сарын 29-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайз, дэлгэц, хөгжим гэрэл	ш	2 өдөр	3,000,000	6,000,000
2	Хөтлөгч	хүн	2 өдөр	800,000	1,600,000
3	Бүжгийн үзүүлбэр /4 хамтлаг/		2 өдөр	200,000	400,000
4	Амьд хөгжмийн хамтлаг	-	2 өдөр	500,000	1,000,000
5	ДиЖи шоу	хүн	2 өдөр	250,000	500,000
6	АХА тэмцээний шагнал	хүн	2 удаа	50,000	100,000
7	Хүүхэлдэйн хувцастай, хоолны хувцастай оролцогчдын тэмцээний шагнал	-	2 удаа	250,000	500,000
8	Арга хэмжээний шилдэг тогооч шалгаруулах уралдааны шагнал	хүн	1	500,000	500,000
9	Цом өргөмжлөл	ш	3	105,000	105,000
10	Ковер дууны тэмцээний шагнал	хүн	1	100,000	100,000
11	Баннер, урилга, стэнд хэвлүүлэх	-	-	300,000	300,000
12	Шторк бэлдэж, цацах	-	-	1,500,000	1,500,000
НИЙТ ДҮН					12,605,000

--ooOoo--

ТӨСӨВ ЗОХИОСОН:  
СТАТИСТИК, СУРГАЛТ, СУДАЛГАА  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *Б.Ербаахыт* Б.ЕРБАХЫТ

ХЯНАСАН:  
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ *Б.Батбаатар* Б.БАТБААТАР